



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Л.МӨНХБАЯСГАЛАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.10.24 № ХХ/2959
танай _____-ны № _____-т

Асуултын хариу хүргүүлэх
тухай

Танаас 2025 оны 37 дугаартай албан бичгээр ирүүлсэн эрчим хүчний үнэ тариф, салбарын бодлогын хэрэгжилтийн талаарх асуултын хариуг Эрчим хүчний сайдаас бэлтгэн ирүүлснийг Танд үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 03 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000255017024

МУИХ-ын гишүүн Л.Мөнхбаясгалангаас ирүүлсэн эрчим хүчний үнэ тариф,
салбарын бодлогын хэрэгжилтийн талаарх асуултын хариу

1. Хэрэглэгчдэд борлуулах цахилгаан болон дулааны тарифыг шинэчлэн тогтооход инфляцын өсөлтийг тооцож үзсэн эсэх, холбогдох судалгаа мэдээлэл, үнэ нэмэх болсон шийдвэрүүд

Эдийн засаг, хөгжлийн яам болон Эрчим хүчний зохицуулах хороо хамтран 2024 оны 8 дугаар сард эрчим хүчний тарифыг шинэчлэн тогтоохын өмнө "Эрчим хүчний тарифын шинэчлэл, тариф нэмэгдүүлсний эдийн засагт үзүүлэх нөлөө" судалгааг хийж, тарифт өөрчлөлт ороход үүсэх инфляцийн нөлөөллийг урьдчилан тооцоолсон.

Судалгааны дүнгээр тарифын өөрчлөлтөөс хойш нэг жилийн хугацаанд нийт 2.45 нэгж хувийн инфляцын нөлөөлөл үүсэхээр гарсан бөгөөд үүнээс шууд нөлөө 1.7 нэгж хувь, шууд бус нөлөө 0.75 нэгж хувь байна.

Эрчим хүчний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.4-д "үнийг инфляцтай уялдуулан тооцох" гэж заасан байдаг.

Айл өрхийн цахилгааны тарифт 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш өөрчлөлт ороогүй бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс шинэчилсэн тарифыг мөрдөж эхэлсэн. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2019 оны 06 дугаар сард хэрэглээний үнийн индекс (2020=100) 97.5 байсан бол 2024 оны 11 дүгээр сард 150.1 болж, энэ хугацаанд 53.95 хувийн нийлбэр инфляц бүртгэгдсэн байна.

Энэ хугацаанд айл өрхийн цахилгааны дундаж тариф 140 төгрөгөөс 212 төгрөг болж, дунджаар 50.8 хувиар нэмэгдсэн нь инфляцийн өсөлттэй ойролцоо байна. Мөн айл өрхийн сарын дундаж орлого 2019 онд 1.36 сая төгрөг байсан бол 2024 онд 2.64 сая төгрөгт хүрч 95 хувиар өссөн нь тарифын өөрчлөлтийг давахуйц орлогын өсөлт гарсныг харуулж байна.

Эрчим хүчний зохицуулах хорооноос эрчим хүчний салбарын үнэ, тарифыг бодит өртөгт нийцүүлэн шинэчлэн тогтоох зорилгоор цахилгааны тарифыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс дараах байдлаар нэмэгдүүлэх шийдвэрийг гарган, мөрдүүлсэн. Үүнд:

Цахилгааны шинэчилсэн тариф:

- Цахилгааны дундаж тариф: 216 → 280 төгрөг (+29.6%);
- Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр: 294 → 342 төгрөг (+16.3%);
- Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага: 222 → 291 төгрөг (+30.7%);
- Айл өрхийн дундаж тариф: 140 → 212 төгрөг (+50.8%);

Өрхийн шаталсан тариф:

- 150 кВт.ц хүртэл: 134.28 → 175.00 төгрөг (+30%);

- 151-300 кВт.ц: 154.08 → 256.00 төгрөг (+66%);
- 301 кВт.ц-аас дээш: 154.08 → 285.00 төгрөг (+85%) болгож өөрчилсөн.

Айл өрх эрчим хүчний хэрэглээг хянах, хэмнэх сонирхлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ өрхийн төлбөрийн ачааллыг бууруулж, ялгавартай байлгах зорилгоор хэрэглээний түвшнээс хамаарсан 3 шатлал бүхий тарифыг нэвтрүүлсэн.

Мөн 2 цагийн ялгаварт тоолууртай хэрэглэгчийн шөнийн цагийн тарифыг 30-42 хувиар өөрчилсөн бөгөөд айл өрхийн цахилгааны хэрэглээг илүү уян хатан удирдах боломжийг бүрдүүлэх зорилгоор 3 цагийн ялгаварт тарифыг шинээр нэвтрүүлсэн. Энэхүү шинэ тарифт 2 цагийн ялгаварт тарифтай харьцуулахад оройн оргил цагийн үнэ өндөр, өдрийн болон шөнийн тариф харьцангуй бага байхаар тогтоосон.

2019 оноос хойш 5 жилийн хугацаанд айл өрхийн цахилгаан болон дулааны эрчим хүчний тарифт өөрчлөлт ороогүй, тогтвортой мөрдөгдсөн. Улсын хэмжээнд нийт 788 мянган ахуйн хэрэглэгч бүртгэгдсэн бөгөөд нэг өрхийн сарын дундаж хэрэглээ 220 кВт.ц байна.

Айл өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний бүтцийг ангилбал:

- 45 хувь нь 150 кВт.ц хүртэл;
- 40 хувь нь 150-300 кВт.ц;
- 11.3 хувь нь 301-2000 кВт.ц,
- 3.8 хувь нь 2001 кВт.ц ба түүнээс дээш хэрэглээтэй байна.

Дулааны эрчим хүчний тарифт 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрөөс дараах өөрчлөлт оруулах шийдвэр гаргасан. Гэвч Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн "Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 132 дугаар тогтоолын дагуу хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифын хэрэгжилтийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хойшлуулсан болно.

Дулааны эрчим хүчний тариф:

- Аж ахуйн нэгж байгууллага: 604 → 1044 төгрөг/м³ (+73%),
- Улаанбаатар хотын орон сууцны айл өрх: 506 → 1012 төгрөг/м² (+100%)
- Дархан, Эрдэнэт, Чойбалсан хотын айл өрх: 648 → 1012 төгрөг/м² (+56%) өөрчлөлт оруулах шийдвэрийг гаргасан.

Бусад аймгийн төвүүд, орон нутагт мөрдөж буй дулааны тариф аж ахуйн нэгжид 1100-2700 төгрөг/м³, айл өрхөд 800-1024 төгрөг/м² байна.

Эрчим хүчний үнэ, тарифын шинэчлэлийн талаар инфляцын урьдчилсан тооцоо бүхий мэдээллийг 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын хуралдаан, Улсын Их Хурал дахь Монгол ардын нам, Ардчилсан намын бүлэгт 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр тус тус танилцуулсан болно.

2. Хэрэглэгчдэд борлуулах цахилгаан болон дулааны тарифын өсөлтийн хувь хэмжээ болон ямар шатлалаар нэмэгдүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл

Цахилгаан эрчим хүчний тарифыг нэмэгдүүлэх төлөвлөгөө одоогоор байхгүй болно.

Дулааны эрчим хүчний тарифын хувьд Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 132 дугаартай "Олон улсын худалдааны тарифын нөхцөл

байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын дагуу хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифын өөрчлөлтийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хойшлуулсан болно. Уг тогтоолоор 2025 оны 5 дугаар сарын 26-наас хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн дараах өөрчлөлт түр хугацаанд хэрэгжээгүй байна. Үүнд:

Дулааны эрчим хүчний тариф:

- Аж ахуйн нэгж байгууллага: 604 → 1044 төгрөг/м³ (+73%),
- Улаанбаатар хотын орон сууцны айл өрх: 506 → 1012 төгрөг/м² (+100%)
- Дархан, Эрдэнэт, Чойбалсан хотын айл өрх: 648 → 1012 төгрөг/м² (+56%)

---o0o---